

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД САНАЛ ДҮГНЭЛТ ГАРГАХ

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ТӨА-2025/07-18-ШТА-НА

Зуунмод 2025 он



Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хөшигжаргал/Утас: 70272582
Цахим хаяг: khushigjargals@audit.gov.mn Аудитын менежер
О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Л.Жаргалсайхан
Утас: 70273465 Цахим хаяг: jargalsaikhen@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Хүрэлбаатар
Утас: 70273465 Цахим хаяг: khurelbaatar@audit.gov.mn



АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ, САНАЛ



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлэх гэж заасны дагуу аймгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт, санал гаргалаа.

Монгол Улсын 2026 оны төсөв УИХ-ын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан.

Улсын төсөв батлагдсантай холбоотойгоор Сангийн яамнаас аймгийн 2026 оны төсвийг хянаж ирүүлсэн.

Аймгийн суурь орлогыг 85,703.8 сая төгрөг

Суурь зарлагыг 71,882.1 сая төгрөг

Улсын төсөвт 4,146.5 сая төгрөг татан төвлөрүүлэх



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 48 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнүүдийн 89,6 хувь нь Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй, 87,5 хувь нь аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй нийцсэн байна.

Аймгийн төсөвт Сангийн яамны хянасан суурь орлогыг 11,586.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж тооцсон байна. Үүнд:

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 6,500.0 сая төгрөг

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 3,000.0 сая төгрөг

Газрын төлбөр 1,550.0 сая төгрөг

Хүү торгуулийн орлого 516.9 сая төгрөг

Төсөвт газрын өөрийн орлого 20.0 сая төгрөг



01

02

03

04

05



АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ, САНАЛ



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сумдын суурь орлого, суурь зарлагын тооцооллоор 8 сум нийт 32,614.0 сая төгрөг аймгийн төсөвт татан төвлөрүүлэхээр

бусад 19 сумд 17,470.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар төлөвлөгджээ.

01 Алтанбулаг сум
127.9 сая

02 Баян сум
825.8 сая

03 Баянжаргалан сум
329.6 сая

04 Баянчандмань сум
317.3 сая

Заамар сум
1,393.5 сая 05

Зуунмод сум
5,995.3 сая 06

Сэргэлэн сум
23,580.3 сая 07

Эрдэнэ сум
44.2 сая 08

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд аймгийн нийт суурь зарлага 86,527.3 сая төгрөгөөр тусгагдсанаас аймгийнх 34,752.0 сая төгрөг, сумдынх 51,775.3 сая төгрөг байна.

Автозамын
сан
2,000.0 сая
төгрөг

Байгаль орчныг
хамгаалах нөхөн
сэргээх арга
хэмжээний
зардалд 770.0
сая төгрөг

Гэмт хэргээс
урьдчилан
сэргийлэх арга
хэмжээний
зардалд
500.0 сая төгрөг

Орон нутгийн
хөрөнгө
оруулалтаар хийх
их засварын
ажилд
2,000.0 сая төгрөг

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2026 онд 22,891.3 сая төгрөг хуваарилагдсан

Аймгийн
ОНХС-нд
8,219.3 сая
төгрөг

Сумдын
ОНХС-нд
14,672.0 сая
төгрөг



Тайлант 2025 оны
шилжих үлдэгдлээр
хийгдэх хөрөнгө
оруулалт, төсөл, арга
хэмжээг 7,000.0 сая
төгрөгөөр тооцсон
байна.



АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН ДҮГНЭЛТ, САНАЛ



Аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 3,109.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломжтой байна.



Аймгийн төсвийн орлого:

- Түрээсийн орлогоор 2025 онд 104.7 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн, 10 сарын байдлаар 192.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. “Очир арвай төв” ХХК-тай Монгол өв соёлын цогцолборыг түрээслэх гэрээ хийж 2024 онд 17.9 сая төгрөг, 2025 онд 19.9 сая төгрөг нийт 38.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 15.9 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна. Мөн Орон нутгийн өмчийн газраас Монгол өв соёлын цогцолборын 18м диаметртэй гэр, хоол бэлтгэх хэсэг, ариун цэврийн өрөө, 27 сумын гэр болон дээрх хөрөнгүүдийг түрээслүүлэхээр түрээсийн сонгон шалгаруулалт зарлаж, 2026 онд 36.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Иймд 2026 оны төсвийн төсөлд Сангийн яамны хянасан 70.0 сая төгрөгийн орлогыг 52.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 122.3 сая төгрөгөөр төлөвлөх боломж байна.
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг борлуулсны орлого 2025 оны 10 дугаар сарын байдлаар 48 хувийн биелэлттэй байгаа ч оны эцэст 70–85 хувь хэрэгжих боломжтой. 2026 оны орон нутгийн өмчийн эд хөрөнгийг борлуулсны орлогын төлөвлөгөөг 50.0 сая төгрөгөөр тооцсон нь өмнөх жилүүдийн бодит гүйцэтгэл, боломжит нөөцийг бүрэн тусгаагүй төлөвлөлт гэж үзэж байна. Орон нутгийн өмчийн хөрөнгийг шийдвэрлэсэн ИТХ-ийн тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 8 иргэнд 145.6 сая төгрөгийн орон сууц, 52 нэр төрлийн 139.9 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл болон бусад хөрөнгийн орлогын боломж байна. Иймээс 2026 оны Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг борлуулсны орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэл болон боломжит эх үүсвэртэй уялдуулан 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 100.0 сая төгрөгөөр төлөвлөх боломжтой байна.

Сумдын ОНХС-ийн орлого:

- Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 -т заасны дагуу энэ төрлийн татварын орлогыг 2024 оны мал тооллогын дүнг үндэслэн ногдуулалтыг тооцож үзэхэд 2,196.1 сая төгрөг болж байна. 2025 онд тус төрлийн татварын орлогод 1,324.1 сая төгрөг ногдуулж, 11 дүгээр сарын байдлаар 84.4 хувийн биелэлттэй байна. Иймд энэ оны гүйцэтгэлийн хувьтай уялдуулан 1,756.9 сая төгрөгөөр тус орлогыг төлөвлөх боломжтой байна.



Аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 3,109.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломжтой байна.

Сумдын төсвийн орлого:

- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2024 онд 3,145.4 сая төгрөгөөр төлөвлөж, 4,268.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 2025 онд 3,281.0 сая төгрөгийн төлөвлөгөө, 10 дугаар сарын байдлаар 3,209.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2026 оны төсвийн төсөлд 3,300.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2025 оны төлөвлөгөөнөөс 19.0 сая төгрөгөөр өссөн байна. 2024 оны орлогын гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон сүүлийн жилүүдэд манай улсад ирэх аялал жуулчлал ихэссэнтэй холбоотой "Улсын тэмдэгтийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасан орлого нэмж орох боломжтой байгаа тул энэ төрлийн орлогыг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,500.0 сая төгрөгөөр төлөвлөх,
- Газрын төлбөр 2025 оны 10 дугаар сарын байдлаар 4,437.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2026 оны төсвийн төсөлд 2025 оны төлөвлөгөөнөөс 59.2 сая төгрөгөөр, УИХ-ын баталсан дүнгээс 1,550.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,950.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Тус орлогын төлөвлөгөөг өмнөх онуудын гүйцэтгэл, газрын дуудлага худалдааны орлогыг төлөвлөөгүй, өмнөх оны газрын төлбөрийн өр 2,881.3 сая төгрөгийн 60 хувийг барагдуулахаар тооцож 700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 4,650.0 сая төгрөгөөр төлөвлөх,
- Хүү торгуулийн орлогыг төлөвлөх бааз суурь нь тодорхойгүй байдаг тул жил жилийн гүйцэтгэлийг харгалзан төлөвлөдөг. 2025 онд энэ төрлийн орлогоор аймаг, сумд 4,758.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөгдсөн, 10-р сарын мэдээгээр 5,186.8 сая төгрөг орсон байна. Сангийн яам 2026 оны хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөг 4,500.0 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 516.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 5,016.9 сая төгрөг байхаар тооцсон байна. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл жил бүр төлөвлөгөө давж биелсэн, Татварын газрын мэдээгээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,503.9 сая төгрөгийн татварын торгуулийн өрнөөс 2025 онд 42.9 сая төгрөгийг барагдуулсан байна. Иймд хүү, торгуулийн орлогын 2026 оны төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сарын гүйцэтгэлийн түвшинд буюу 170.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 5,186.9 сая төгрөгөөр төлөвлөх,
- Нэр зааж ангилаагүй орлогыг 2025 оны аймгийн төсвийн орлогод 500.0 сая төгрөг, орон нутгийн орлогод 220.5 сая төгрөг, нийт 720.5 сая төгрөгөөр баталсан байна. 2025 оны 10 дугаар сарын байдлаар аймаг, сумдын төсөвт 907.2 сая төгрөгийн орлого орсон байна. 2026 онд аймгийн төсөвт 730.1 сая төгрөг төлөвлөж, сумын төсөвт энэ төрлийн орлого төлөвлөөгүй байна. Өмнөх оны гүйцэтгэлээс бууруулахгүйгээр 180.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 910.1 сая төгрөгөөр төлөвлөх.



БУСАД АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТАЛААР

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд аудит хийхэд аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалт, шилжих үлдэгдлээр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тусгагдсан дараах ажлууд аймгийн ЗДҮАХ, аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. Үүнд:

- Төсөвт байгууллагуудын автомашин шинэчлэх зардал /ИТХ, Шүүх, Улсын бүртгэл/-379.0 сая төгрөг.
- Сумын автомашин шинэчлэх зардал /5 сум/ -400.0 сая төгрөг.
- Орон нутгийн дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд олгох татаас /Зуунмод/ -2,000.0 сая төгрөг.
- Аймгийн ЗДТГ-т ёслол хүндэтгэлийн өргөө шинэчлэн, засварлах -200.0 сая төгрөг.
- Архуст сумын Ноёншанд багийн төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт-150.0 сая төгрөг.

Цаашид орон нутгийн төсвийн төлөвлөлтийг ЗДҮАХ, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд ус ашигласны төлбөр 2,200.0 сая төгрөгөөр төлөвлөж, аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 770.0 сая төгрөг зарцуулахаар тооцсон. Ус ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр зардлыг төлөвлөсөн ч зардлын жагсаалтад тусгасан төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.1-д заасантай нийцэхгүй байна. Цаашид энэ журмын 3.1-д заасан “байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна” гэснийг баримталж ажиллах шаардлагатай байна.



БУСАД АНХААРАХ ЗҮЙЛСИЙН ТАЛААР

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд нийт 3 эх үүсвэрээс 29,194.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардалд бүгд 17,267.0 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөсөн байна. Үүнээс хөрөнгө оруулалт, их засварын 12,000.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 ажлаас 2,078.0 сая төгрөгийн 13 их засварын ажил зураг, төсөвгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹.2-д заасан шаардлагад нийцэхгүй. Цаашид хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад хуульд нийцсэн төсөл арга хэмжээг тусгахад анхаарах шаардлагатай байна.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т “...зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-с доошгүй хувийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах, 20-с доошгүй хувийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ гэж заасан буюу нийт орлогын 40-с доошгүй хувийг ГХЗУСАХЗ-д зарцуулахаар байна. Аймгийн 2026 оны хүү торгуулийн орлогод 1,500.0 сая төгрөг орохоор төлөвлөсний 33,3 хувийг буюу 500.0 сая төгрөгийг аймгийн ГХЗУСАХЗ-д, сумдын хувьд 3,516.9 сая төгрөгийг орохоор төлөвлөсний 19,2 хувь буюу 675.4 сая төгрөгийг сумдын ГХЗУСАХЗ-д зарцуулахаар төлөвлөсөн нь хуульд заасан хувь хэмжээнд хүрэхгүй байна. Цаашид ГХЗУСАХЗ-г төлөвлөхдөө хуульд заасан хувь хэмжээг баримтлах, хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг хуульд нийцүүлэн батлахад анхаарах хэрэгтэй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2 суманд хөдөө, аж ахуйн техник дундын төвийн тоног төхөөрөмж байгуулах зардал”-д 800.0 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөжээ. Нэг суманд 266.0 сая төгрөгийн тоног, төхөөрөмж худалдан авахаар тооцоолол хийгдсэн байхад хоёр суманд 800.0 сая төгрөгийн зардал төлөвлөсөн нь 268.0 сая төгрөгөөр илүү байна. Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээс “Батсүмбэр суманд сүүний цех байгуулахад” 400.0 сая төгрөг төлөвлөжээ, гэтэл тус цехийн барилга 343.4 сая төгрөг, зураг 26.0 сая төгрөг, нийт 369.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байна. Өөрөөр хэлбэл аймгийн ОНХС-ийн хөрөнгөөс 268.0 сая төгрөг, шилжих үлдэгдлээс 30.6 сая төгрөг, нийт 298.6 сая төгрөгийг өөр тулгамдсан, чухал шаардлагатай төсөл арга хэмжээг санхүүжүүлэх боломжтой байна.



ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Сангийн яам аймгийн 2026 оны төсвийн суурь орлогыг 85,703.8 сая төгрөг, суурь зарлагыг 71,882.1 сая төгрөгөөр хянаснаар, үндсэн тэнцэл ашигтай гарч улсын төсөвт 4,146.5 сая төгрөг татан төвлөрүүлэх болсон байна.
- Аймгийн 2026 оны төсвийн төсөлд хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд, богино хугацааны баримт бичигтэй нийцээгүй зарим төсөл, арга хэмжээ тусгагдсан байна.
- Аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын жагсаалтад 8 төсөл арга хэмжээ тусгагдсанаас 440.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ буюу 57,1 хувь нь усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавихтай холбоогүй байна.
- Хүү торгуулийн орлогоос аймгийн ГХЗУСАХЗ-д 33,3 хувь, сумдын ГХЗУСАХЗ-д 19,2 хувьтай тэнцэх хэмжээний зардлыг зарцуулахаар төлөвлөсөн нь хуульд заасан хувь хэмжээнд хүрэхгүй байна.
- Аудитын явцад хийсэн судалгаанд үндэслэн 2026 оны аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 3,109.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөх боломжтой байна.
- Өмнөх онуудад ногдуулсан татварын өр барагдуулалтын хувь зорилтот түвшиндээ хүрэхгүй байгаа тул өр барагдуулах талаар тодорхой, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.
- ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹.2-д заасан шаардлагыг хангаагүй зарим ажлууд тусгагдсан байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга Л.Төмөрчөдөр танд зөвлөж байна. Үүнд:

- Аймгийн төсвийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг хууль тогтоомжтой нийцүүлэхэд анхаарч ажиллах.
- Өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалтыг зорилтот түвшинд хүртэл барагдуулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч ажиллах.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29¹.2-д заасан шаардлагыг хангаж ажиллах.